



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 29 өдөр

Дугаар A/43

Хэрлэн сум

**“Тэмүүжин” амины орон сууц,
апартмент хорооллын төслийг хэрэгжүүлэх
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Тэмүүжин” амины орон сууц, апартмент хорооллын төслийн хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомж, журам заавар, стандарт, норм дүрмийн дагуу зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн

дарга:

Хэрлэн сумын газрын даамал

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга


Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын

Газрын удирдлагын хэлтсийн дарга

2.Төслийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, улирал бүр үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

